



ДАЛАЙВАН АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан





ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ -ын Удирдах Зөвлөлд

Бидний дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон гол чухал нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Яамны 386-р тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Хараат бус байдал

Бид Олон Улсын Ёс зүйн Хорооноос гаргасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-аас хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын жилийн тайланг хамааруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт тайлан багтаагүй. Аудиторын тайлан гарахаас өмнө Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын 2019 оны жилийн тайлан бэлтгэсэн.

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан (ХДС) нь “Хамтын ажиллагааны гэрээ”, Сангийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа ил тод зохион байгуулж Сангийн удирдах зөвлөлөөс санхүүжүүлэхээр баталсан орон нутагт хэрэгцээтэй төсөл, хөтөлбөрүүдийг журмын дагуу санхүүжүүлэн, сангийн дүрэм, холбогдох журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.


Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага, төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоохоос шийдсэнээс бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын үйл ажиллагааг зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх үүргийг хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагналыг байнга илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын дотоод хяналтын үр дүнтэй байдал дүгнэлт өгөх зорилгогүй.
- Байгууллагын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.



2020 ОНЫ 07 ДУГААР
САРЫН 21-НИЙ ӨДӨР

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт		2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3.1	6,378,256.6	5,378,787.7
Авлага		-	-
Бараа материал		-	-
Урьдчилж төлсөн зардал		-	-
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3.2	748,433.3	1,130,315.9
Эргэлтийн хөрөнгийн дүн		7,126,689.9	6,509,103.6
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3.3	74,797.9	79,197.9
Хуримтлагдсан элэгдэл-үндсэн хөрөнгө		(18,060.6)	(32,003)
Биет бус хөрөнгө (цэвэр)	3.4	1,059.6	463.4
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		57,796.9	47,658.3
НИЙТ ХӨРӨНГӨ		7,184,486.8	6,556,761.9
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Эргэлтийн өр төлбөр			
Дансны өр	3.5	6,649,007.7	2,973,962.3
Татварын өр		-	-
Банкны богино хугацаат зээл		-	-
Урьдчилж орсон орлого		-	-
Бусад өр төлбөр		-	-
Эргэлтийн өр төлбөрийн дүн		6,649,007.7	2,973,962.3
Цэвэр хөрөнгө			
Хязгаарлалтгүй нөөц		-	-
Хуримтлагдсан үр дүн	3.6	535,479.1	3,582,799.6
Цэвэр хөрөнгийн дүн		535,479.1	3,582,799.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		7,184,486.8	6,556,761.9

Баталсан:

 ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ
 С.Эрдэнэбат
 Гүйцэтгэх захирал

Бэлтгэсэн:



Б.Батхуяг
 Ерөнхий нягтлан бодогч

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ

ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт		2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Үндсэн үйл ажиллагааны орлого			
Хөтөлбөр, төслийн орлого	3.7	12,094,300.0	13,162,600.0
Бэлэг, хандив, тусламжийн орлого		-	-
Бусад орлого	3.7	208,789.1	517,779.9
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн		12,303,089.1	13,680,379.9
Үндсэн үйл ажиллагааны зардал			
Төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэлтийн зардал	3.8	16,878,312.5	9,637,287.4
Байгууллагад өгсөн хандив тусламж	3.8	175,412.6	349,088.7
Тэтгэлэгт хөтөлбөрийн зардал	3.8	135,471.6	155,557.8
Цалин хөлс, шагнал		171,048.0	201,829.7
Нийгмийн даатгалын шимтгэл		20,525.7	25,131.9
Засвар үйлчилгээний зардал		714.6	1,952.8
Бичиг хэргийн зардал		13,629.5	13,839.6
Түрээсийн зардал		16,988.4	17,038.2
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал		4,267.5	1,600.0
Тээврийн зардал		-	-
Элэгдлийн зардал		13,566.2	14,538.6
Зар сурталчилгааны зардал		151,070.2	106,167.2
Шуудан, холбооны зардал		3,834.2	4,260.8
Шатахууны зардал		7,097.6	10,883.9
Хангамжийн материалын зардал			
Сургалтын зардал			
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал			
Хурал, семинарын зардал			
Бусад зардал		138,740.3	93,882.8
Үндсэн үйл ажиллагааны нийт зардал	3.9	541,482.2	491,125.5
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		(5,427,589.8)	3,047,320.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого ба зардал			
Валютын ханшийн зөрүүний ашиг/(алдагдал)		150,000.0	
Бусад орлого/зардал		(1,147.1)	
Үндсэн бус үйл ажиллагааны үр дүн	3.10	148,852.9	
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН		(5,278,736.9)	(3,047,320.5)



Бэлтгэсэн:

Б.Батхуяг
Ерөнхий нягтлан бодогч

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ
ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт	Хязгаарлалтгүй нөөц	Хязгаарлалттай нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	5,814,216.0	5,814,216.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	5,814,216.0	5,814,216.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр үр дүн	-	-	-	(5,278,736.9)	(5,278,736.9)
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	535,479.1	535,479.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	535,479.1	535,479.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр үр дүн	-	-	-	3,047,320.5	3,047,320.5
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	3,582,799.6	3,582,799.6

Бэлтгэсэн:



Б.Батхуяг
 Ерөнхий нягтлан бодогч



Баталсан:

С.Эрдэнэбат

Гүйцэтгэх захирал

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Үйл ажиллагааны орох мөнгөн гүйлгээ	12,256,499.7	14,446,439.8
Төсөл, хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	12,244,300.0	13,162,600.0
Бэлэг, хандив, тусламжаас хүлээн авсан мөнгө	-	-
Бусад үйл ажиллагаанд хүлээн авсан мөнгө	12,199.7	1,283,839.8
Үйл ажиллагааны гарах мөнгөн гүйлгээ	(13,803,946.2)	(15,576,008.1)
Ажиллагчдад олгосон мөнгө	(142,099.9)	(167,162.1)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(34,087.0)	(42,380.0)
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	(228.8)	0.0
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(18,397.8)	0.0
Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэгт төлсөн	(13,991.7)	(12,840.7)
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	(13,577,948.1)	(15,335,549.7)
Төлсөн хүү	-	-
Төлсөн татвар	(17,096.4)	(17,959.8)
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	(96.5)	(115.8)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,547,446.5)	(1,129,568.3)
Хөрөнгө оруулалтын орох (гарах) мөнгөн гүйлгээ		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	-	-
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(14,454.7)	(4,399.9)
Худалдаж авсан богино хугацаат хөрөнгө оруулалт	(748,433.3)	(256,885.0)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(762,888.0)	(261,284.9)
Санхүүгийн орох (гарах) мөнгөн гүйлгээ		
Банкнаас авсан зээл	-	-
Банкны зээлийн төлөлт	-	-
Хүүгийн орлого	208,789.1	391,384.3
Валютын ханшийн зөрүүний ашиг/(алдагдал)	-	-
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	208,789.1	391,384.3
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,101,545.4)	(999,468.9)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,479,802.0	6,378,256.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,378,256.6	5,378,787.7

Баталсан:
 №15210513 6180535

 ГОВИЙН ОЮУ
 ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
 САН ТББ
 С.Эрдэнэбат
 Гүйцэтгэх захирал

Бэлтгэсэн:



Б.Батхуяг
 Ерөнхий нягтлан бодогч

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2015 оны 9-р сарын 23-ны өдөр No.8186995 регистрийн дугаар бүхий No.64947 дугаартай Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авснаар Төрийн бус байгууллагаар бүртгэгдэж, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, Оюу Толгой ХХК-тай хамтран сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлтэй.

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/08 тоот тушаалаар Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн нэр, логоог эзэмшигч №40-0018507 тоот онцгой эрхийн гэрчилгээ авсан.

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ыг Удирдах Зөвлөлийн баг удирдана. 2019 оны туршид дараах гишүүдтэй байсан.

Удирдах Зөвлөл

<u>Нэр</u>	<u>Албан тушаал</u>
Тим Экерсли	Удирдах Зөвлөлийн Дарга–Оюу Толгой ХХК-ийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал
Х. Сугир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Н.Наранбаатар	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Засаг дарга
Б.Эрдэнэ-Очир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн ИТХ-ын Ханбогд сумаас сонгогдсон төлөөлөгч
Лаура Томс	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн Сургалт, хүний нөөц хариуцсан ерөнхий менежер
Д.Амарбаясгалан	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал
Ш.Байгалмаа	Удирдах Зөвлөлийн Гишүүн – Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер

Ажлын алба

<u>Нэр</u>	<u>Албан тушаал</u>
С.Эрдэнэбат	Гүйцэтгэх Захирал
С.Болдмаа	Төслийн менежер
Б.Сугаржаргал	Төсөл хөтөлбөрийн ажилтан
Б.Батхуяг	Санхүүгийн ажилтан

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн албан ёсны хаяг:
Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв, 4 давхар 404 тоот Утас/Факс: 976-70533577/976-70533578, цахим шуудан: www.goviinoou.mn

Бейкер Тилли Интернэйшнл (Baker Tilly International)-ийн Монгол Улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн Далайван Аудит ХХК, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж, өөрийн байр

"DALAYVAN AUDIT" Co.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

а) Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэх бөгөөд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ийн дагуу аккрузл суурийг хэрэглэсэн.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Сангийн Сайдын 386-р тушаалаар батлагдсан маягтын дагуу Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэсэн.

б) Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урт хугацаат өр төлбөрөөс бүрдэнэ.

в) Тасралтгүй байдал

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

г) Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Санхүүгийн тайланг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын бүртгэлийн валют болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний олз эсвэл гарзыг үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд тусгагдана.

д) Тайлангийн толилуулга

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн дансдын үлдэгдлийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангийн дансдын үлдэгдэлтэй харьцуулан тайлагнасан.

е) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд гар дээрх бэлэн мөнгө, банканд байгаа мөнгө болон 3 сар хүртэл хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө багтана.

ж) Авлага

Авлагыг бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний зардлын нийлбэрээр анхлан хэмжинэ. Дараа үеүдэд нь үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

h) Урьдчилж төлсөн төлбөр/тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зардлыг хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал/тооцоо гэж бүртгэнэ. Харин бараа, ажил үйлчилгээг хүлээн авсан үед нь хөрөнгө эсвэл тухайн тайлант үеийн холбогдох зардлаар тохируулан бүртгэнэ.

i) Бараа материал

Бараа материалд байгууллагын хэвийн үйл ажиллагааны үед өөрийн дотоод хэрэгцээнд шаардлагатай хангамжийн зүйлс хамаарна.

Бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбогдон гарсан зардлуудыг бараа материалын өртөгт оруулж тооцдог. Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, импортын хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно. Худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасаж худалдан авалтын өртгийг тодорхойлно. Тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлнэ. Ашиглалтад тавьж олгосон бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тооцно.

j) Биет болон биет бус хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр толилуулна. Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлж, элэгдлийн хэмжээгээр санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа:

- Компьютер, түүний дагалдах хэрэгсэл - 3 жил
- Тавилга, эд хогшил - 10 жил
- Тээврийн хэрэгсэл – 10 жил

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа:

- Санхүүгийн программ - 3 жил
- Төсвийн программ - 3 жил

k) Өр төлбөр

Өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Өр төлбөрийг төлөх хугацаа болон гэрээний үүргээс хамааруулан богино болон урт хугацаат гэж ангилна. Тэдгээр өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага дуусвар болсон чөлөөлөгдсөн үед үл хүлээн зөвшөөрнө.

l) Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм. Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд түр хугацаанд хязгаарлалт тавьсан бол уг зорилго эсвэл цаг хугацааг хангагдах үед орлого хүлээн зөвшөөрнө.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд аливаа хязгаарлалт тавиагүй бол нөөцийг олж авах үед орлого хүлээн зөвшөөрнө.

м) Орлого, зардал

Төрийн бус байгууллагын дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Гадаад болон дотоодын байгууллага, гишүүд болон хүмүүсээс хариу төлбөргүй хүлээн авсан санхүүжилт, хандивыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Төрийн бус байгууллага нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зардлыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу хүлээн зөвшөөрнө. Аккруэл суурьт бүртгэлийн хувьд ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зардлыг батлагдсан төсөв, удирдах зөвлөлийн шийдвэр, гэрээ болон зохих анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зардлыг тухайн гарсан жилд нь санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

н) Татвар

Төрийн бус байгууллага нь:

- Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 4.1.5-д “ Аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг ойлгоно” гэж заасан. Дээрх хуулийн заалтад ААНОАТ төлөгч нь ашгийн төлөө ажилладаг Аж ахуйн нэгж гэдгийг заасан байна. Иймээс Төрийн бус байгууллага нь орлогын татвар төлөх үүрэг хүлээхгүй.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалингаас хувь хүний орлогын албан татвар (10%)-ыг хуульд заасны дагуу суутган авч татварын байгууллагад тайлагнадаг.

о) Нийгмийн даатгалын шимтгэл

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийн ажил олгогчоос 13.5 хувь, даатгуулагчаас 12.5 хувийг төлөх үүрэгтэй. Тайланг бэлтгэн гаргаж нийгмийн даатгалын байгууллагад тайлагнадаг.

р) Холбоотой тал

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
- Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- (i) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- (ii) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй группийн нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- (iii) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- (iv) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
- (v) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
- (vi) Байгууллагад (1)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- (vii)(1), (1)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,
- (viii) Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах,

q) Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээх магадлалтай, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Болзошгүй өр төлбөрийг тайлант хугацааны эцэст байгаа одоогийн үүрэг хариуцлагыг барагдуулахын тулд удирдлагын хийсэн шаардлагатай зардлын хамгийн сайн тооцооллын өнөөгийн үнэ цэнээр хэмжих бөгөөд төлөгдөх нь тодорхой болох хүртэл болзошгүй өр төлбөрийг зөвхөн тодруулна.

"DALAYAN AUDIT" Co., Ltd
CERTIFIED ACCOUNTING AUDITORS
& APPRAISAL

3. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. Тодруулга-Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Бэлэн мөнгө:		
Төгрөг	116.7	576.1
Банкин дахь харилцах:		
Төгрөг	6,378,139.9	5,378,211.6
Дүн	<u>6,378,256.6</u>	<u>5,378,787.7</u>
	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Банкин дахь харилцах:		
Хаан банк-5585698858	5,428,553.9	4,300,576.2
Хаан банк-5585644465	76,998.6	64,712.9
Хаан банк-5585673654	61,619.8	58,732.2
Хаан банк-5585672708	118,683.3	5,021.0
Хаан банк-5585675200	692,284.3	949,169.3
Дүн	<u>6,378,139.9</u>	<u>5,378,211.6</u>
Хаан банк- хадгаламж 5585675222	-	-
Дүн	-	-
Мөнгөн хөрөнгийн дүн	<u>6,378,139.9</u>	<u>5,378,211.6</u>

- Хаан банк дахь 5585698858 тоот төгрөгийн харилцах данс нь Оюу Толгой ХХК-иас төсөл, хөтөлбөрийн санхүүжилт хүлээн авч Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан төсөл хөтөлбөр болон Сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, бусад дэд дансуудад шилжүүлэх зориулалттай төслийн тусгай данс байна.

Уг данснаас төслийн санхүүжилт болон бусад төлбөр тооцоог хийхдээ “Төлбөр гүйцэтгэх зөвшөөрөл” тусгай маягт ашиглан төлбөрийг хийдэг байна. Ингэхдээ гэрээ, хэлцэл болон бусад санхүүгийн баримт материалыг үндэслэн Сангийн удирдлагын багийн зөвшөөрлөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нарт болон Сангийн үйл ажиллагааны дансуудад шилжүүлэг хийдэг байна.

Тайлант хугацаанд Оюу Толгой ХХК-иас шилжүүлсэн 13,162,600.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг тус дансанд хүлээн авч орлогоор бүртгэсэн. Тус дансны үлдэгдэлд 373,010.8 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.

- Хаан банк дахь 5585644465 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Сангийн үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд ашигладаг дэд данс байна. Тус дансны үлдэгдэлд 11,934.0 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.

"DALAIVAN AUDIT" Co., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDIT
& APPRAISAL

3.1. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө (үргэлжлэл)

- Хаан банк дахь 5585673654 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг “Говийн Оюу- Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа төслийг санхүүжүүлэхэд ашигладаг дэд данс байна. Тайлант хугацаанд тус дансанд 128,442.5 мянган төгрөгийн оюутны тэтгэлгийн мөнгө нэмж байршуулж, 132,659.8 мянган төгрөгийг тэтгэлэг олгосон. Дансны үлдэгдэлд 3,388.7 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.
- Хаан банк дахь 5585672708 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Өмнөговь аймаг болон бусад сумдын нийгмийн ажил, байгаль цаг уураас үүдэлтэй тулгарсан бэрхшээлийг даван туулах зэрэгт хандив, тусламж үзүүлэхэд ашигладаг дэд данс байна. Тус хандив тусламжийн сангийн дансанд 256,885.0 мянган төгрөгийг нэмж зузаатгасан. Дансны үлдэгдэлд 3,050.8 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.
- Хаан банк дахь 5585675200 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн зорилтод бүлгийн жижиг дунд бизнесийн зээлийг дэмжих зорилготой дэд данс байна. Тайлант хугацаанд тус дансанд 256,885.0 мянган төгрөгийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нэмж байршуулсан.

3.2. Богино хугацаат хөрөнгө оруулалт

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Хугацаатай хадгаламж	748,433.3	1,130,315.9
Дүн	<u>748,433.3</u>	<u>1,130,315.9</u>

Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн данс нь Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сангаас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулсан хадгаламж юм. Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны №03 тоот тогтоолоор баталсан “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хойч үеийн төлөө сан, мөн Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдрийн №05 тоот тогтоолоор баталсан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан”-ийн журмыг тус тус үндэслэн 2016 оны 12 сарын 20-ний өдөр Өмнөговь аймгийн Хаан банкны салбарт 100,000 ам.доллартой тэнцэх хэмжээний буюу 200,498.0 мянган төгрөгийн хадгаламжийг 1 жилийн хугацаатай, сарын 1.3 хувь (жилийн 16 хувь) хүү тооцуулж байх хадгаламжийн гэрээг байгуулсан. Талууд гэрээг жил бүр сунгалт хийж нийт 10 жилийн хугацаатай байхаар гэрээ байгуулсан байна.

Тайлант хугацаанд тус дансанд 256,885.0 мянган төгрөгийг хадгаламжийн эх үүсвэрт нэмж хуримтлуулж тайлант оны эцсийн байдлаар нийт 1,130,315.9 мянган төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл тайлагнасан.

"DALAYVAN AUDIT" Co., Ltd.
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

3.3. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт дүн
Анхны өртөг:					
2018.12.31-ний үлдэгдэл	11,360.4	33,943.6	18,000.0	11,493.9	74,797.9
Худалдаж авсан	1,950.0	2,450.0			4,400.0
Хасагдсан:					
2019.12.31-ний үлдэгдэл	13,310.4	36,393.6	18,000.0	11,493.9	79,197.9
Хуримтлагдсан элэгдэл:					
2018.12.31-ний үлдэгдэл	1,261.6	13,272.0	1,799.0	1,728.0	18,060.6
Нэмж байгуулсан элэгдэл	1,075.7	9,918.9	1,799.0	1,148.8	13,942.4
Хасагдсан					
2019.12.31-ний үлдэгдэл	2,337.3	23,190.9	3,598.0	2,876.8	32,003.0
Үлдэгдэл өртөг:					
2018.12.31-ний үлдэгдэл	10,098.7	20,671.6	16,200.9	9,765.9	56,737.1
2019.12.31-ний үлдэгдэл	10,973.0	13,202.7	14,401.9	8,617.1	47,194.7

“Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 12 сарын 20-ны өдрийн 34 тоот тушаалаар 2 хүний бүрэлдэхүүнтэй эд хөрөнгийн тооллого хийх комисс томилогдож тооллогыг 2019.12.20-ноос 24-ний хооронд тооллого хийсэн байна.

Тооллогоор илүүдэл болон дутагдал илрээгүй байна.

“DALAIAN AUDIT” Co.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

3.4.Биет бус хөрөнгө (цэвэр)

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Санхүүгийн программ хангамж	990.0	990.0
Төсөвийн программ	800.0	800.0
Хуримтлагдсан хорогдуулга	(730.4)	(1,326.5)
Биет бус хөрөнгийн дүн	<u>1,059.6</u>	<u>463.4</u>

3.5.Өр төлбөр

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Дансны өглөг	6,649,007.7	2,973,962.3
Өр төлбөрийн дүн	<u>6,649,007.7</u>	<u>2,973,962.3</u>

Өр төлбөрийн дүнг харилцагчаар нь харуулбал:

Харилцагчын нэр	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Говийн өгөөж ХБ СЦК	304,084.1	0.0
Нарны цаг	46,457.5	0.0
Экологбус ХХК	17,500.0	17,500.0
Очир-Энерги ХХК	18,286.5	18,286.4
Билэгт багана мал эмнэлгийн тоног төхөөрөмж	6,894.4	0.0
Гүмүда девелоп ХХК	8,000.0	8,000.0
Холимог сургалтын институт ТББ	20,027.8	20,027.8
Ханбогд сумын ахмадын хороо	0.0	3,840.0
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	5,000.0	0.0
Билэгт багана гадна холбоо	10.0	0.0
Говийн өгөөж ЕБС бие засах газар	1,982.5	1,982.5
Хайрхан баян бор ХХК	1,050.8	1,511.1
Аглут ХХК	3,477,000.0	1,208,675.8
Гүүд рүүт интертрейдинг ХХК	975,000.0	48,750.0
Мөнх-Өргөө ХХК	591,422.4	591,422.4
Хос бор морь ХХК	479,650.8	59,956.3
Шинэ эрин лаборатори сургууль	145,000.0	7,250.0
Загийн худаг ХХК	136,410.0	11,367.5
Суварган говь ХХК	72,428.7	0.0
Би Эм Грийн Палас	68,123.2	0.0
Энхбодиз ХХК	48,522.6	0.0
Өм. БОЭТ	42,028.4	42,028.5
Болор ус ХХК	31,908.2	7,977.0
Нэмэхт суурь ХХК	30,000.0	1,500.0
Номгон хөгжлийн гарц ТББ	16,800.0	0.0
Ханбогд хөгжлийн төлөө ТББ	11,470.0	0.0
Меджей ХХК	10,472.5	10,472.5

Би Ти Жи Ти ХХК	10,000.0	1,250.0
Бадрангуй-Орших ХХК	9,195.0	0.0
Мехатроник ХХК	7,699.5	0.0
Б.Төмөрбаатар	7,500.0	0.0
Шүүдэр гранд ХХК	5,496.6	0.0
Оргилын хур ТББ	5,469.7	0.0
Содон-Эрчис ХХК	5,226.4	5,226.4
Оюуны өргөө ханбогд ТББ	5,223.0	870.5
Сетунари ХХК	2,450.0	2,450.0
Өлзийт говь констракшн ХХК	2,440.8	2,440.9
Вижн Межик ХХК	2,434.0	275.0
Элбэг туулай ХХК	2,433.9	8,252.8
Эрүүл насжилт ТББ	2,122.6	2,869.2
Нуган ХХК	2,100.0	0.0
Тангад Араа ХХК	1,997.0	0.0
Ногоон төгөл нөхөрлөл	1,770.0	0.0
ХБ 21 -р цэцэрлэг	1,448.8	0.0
О.Цэнджаргал	1,400.0	0.0
Билгүүн-Од констракшн ХХК	1,387.2	0.0
5-р сургууль	1,120.0	0.0
Лидердент ХХК	769.7	0.0
Ньюскай стар ХХК	710.0	710.0
Г.Баттөр	583.4	0.0
Очир-энерги кабинет тохижуулах	549.9	549.9
Ш.Лхагвасүрэн	498.7	498.7
Н.Баттулга	498.1	498.1
Тэнгэрийн мэлмий ХХК	453.0	453.0
Диваажингийн зам хоршоо	300.0	0.0
Өм, Боловсрол соёл урлагын газар	200.0	0.0
Рехтус ХХК	0.0	2,000.0
Баянзаг динозавр ХХК	0.0	12,789.2
Кокс заг ОНӨААТҮГ	0.0	1,883.5
ХААИС-МААБС	0.0	19,500.0
Удмын урлан ХХК	0.0	1,170.0
Вентана констракшн ХХК	0.0	310,746.3
Пирамид капитал ХХК	0.0	14,000.0
Ц.Энхтөр	0.0	479.2
Саудгоби капитал ХХК	0.0	1,172.1
Авто замын хөдөлгөөний хөгжлийн гарц ТББ	0.0	3,500.0
Б.Мөнх-Ундрэм	0.0	943.9
А.Гантөмөр	0.0	498.7
Эс жи эм ХХК	0.0	2,649.9
Ж.Баатар	0.0	1,245.0
Говийн яруу эгшиглэн ХХК	0.0	7,630.0
Арц суварга	0.0	251,542.3
Шүтээн-Эрдэнэ ХХК	0.0	45,091.9
Хишиг-Юниверс ХХК	0.0	10,500.0
Галбын өгөөж хоршоо	0.0	1,000.0
Х.Амбаа	0.0	4,620.0
Д.Ганбат	0.0	12,647.4
Д.Хүдэрбат	0.0	4,000.0
Халбас хайрханы хишиг ХХК	0.0	1,393.7
Мандал стиль ХХК	0.0	499.0
Д.Ганболд	0.0	750.0
Б.Далайхүү	0.0	625.0
Б.Бүжин	0.0	1,000.0

Говийн гурван баг хоршоо	0.0	3,500.0
Дархан төгөлдөр говь ХХК	0.0	1,698.0
Тэргүүн суварга ХХК	0.0	3,000.0
Ц.Бямбажав	0.0	3,163.0
Б.Ичинхорол	0.0	492.3
Мөнх ногоон галба ТББ	0.0	2,000.0
Н.Уртнасан	0.0	1,614.0
Ч.Амартүвшин	0.0	1,500.0
Мөнх ногоон тал ХХК	0.0	14,538.8
Аз билэгтэй ХХК	0.0	490.5
Говь хангайн андууд ХХК	0.0	900.0
А.Ууганбаяр	0.0	1,500.0
Натурал морнинг ХХК	0.0	1,702.1
Логмон ХХК	0.0	74,025.2
Дүжий хайрхан ХХК	0.0	43,069.0
Баянговь ус ХХК	0.0	20,000.0
Нийт	6,649,007.7	2,973,962.3

3.6 Цэвэр хөрөнгө

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Хязгаарлалтгүй нөөц	-	-
Хязгаарлалттай нөөц	-	-
Хуримтлагдсан үр дүн	535,479.1	3,582,799.6
Цэвэр хөрөнгийн дүн	535,479.1	3,582,799.6

3.7 Хандив тусламжийн орлого

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Тусламжийн орлого	12,094,300.0	13,162,600.0
Хандиваар авсан хөрөнгийн орлого	-	-
Хүүний орлого	208,789.1	517,779.9
Оюутны сургалтын төлбөрийн буцаалтын орлого	-	-
Нийт орлого	12,303,089.1	13,680,379.9

- Тусламжийн орлого:

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-иас жил бүр 5,000,000 ам.доллартой тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгох гэрээтэй. Гэрээний дагуу санхүүжилт орж ирж орлогоор бүртгэсэн.

“DALAYVAN AUDIT” Co., Ltd.
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

- Хүүний орлого:

Хаан банк дахь 5585698858, 5585644465, 5585673654, 5585672708 тоот төгрөгийн харилцах дансдуудын үлдэгдэлд тооцсон 391,384.3 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн.

Мөн Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн дансанд сарын 1.3 хувь (жилийн 16 хувь) хүү тооцуулж байхаар хадгалуулсан. Тайлант хугацаанд 124,997.6 мянган төгрөгийн хүүний орлого тус тус олсон байна.

3.8 Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний зардал

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Төсөл, хөтөлбөрийн зардал	16,878,312.5	9,637,287.4
Хандив ба тусламжийн зардал	175,412.5	349,088.7
Оюутаны тэтгэлэгт	135,471.6	155,557.7
Нийт зардал	<u>17,189,196.6</u>	<u>10,141,933.8</u>

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу Оюу Толгой ХХК-аас олгосон санхүүжилтийг дараах байдлаар зарцуулсаныг ангилж харуулбал.

Төслийн чиглэлээр	Зарцуулсан зардал: мянган төгрөг	
	2018.12.31	2019.12.31
Нийгмийн дэд бүтэц, барилга	9,681,773.3	4,832,223.1
Байгаль орчин менежмент	986,690.2	41,717.0
Нийгэмд чиглэсэн сургалт, үйлчилгээ	5,013,046.7	1,822,437.3
Мал аж ахуй, бэлчээрийн менежмент	42,336.5	843,536.9
Түүх соёлын өв, аялал жуулчлал	66,642.9	248,446.3
Орон нутгийн бизнес хөгжил	570,800.0	1,400,025.3
Усны менежмент	517,022.9	448,901.5
Хандив, тусламж	175,412.5	349,088.7
Тэтгэлэгт хөтөлбөр	135,471.6	155,557.8
Дүн	<u>17,189,196.6</u>	<u>10,141,933.9</u>

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу тайлант онд санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрийн талаар түүвэрлэн харуулбал:

"DALAYVAN AUDIT" CO., LTD.
CERTIFIED ACCOUNTING, AUDIT
& APPRAISAL

(i) Нийгмийн дэд бүтэц, барилга:

Өмнөговь аймгийн Даланзадгад сум. Музейн барилга:

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Аглут ХХК

Санхүүжүүлэх дүн: 5,795,000,000 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 5,215,500,000 төгрөг

Барилгын ажлын явцын зураг: Үргэлжилж байгаа.



Өмнөговь аймгийн Манлай сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга:

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Вентана констракшн ХХК

Санхүүжүүлэх дүн: 1,553,731,260 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 1,476,044,697 төгрөг

Барилгын зураг: Дууссан.




Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын уурын зуухны барилга:

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Шүтээн Эрдэнэ ХХК

Санхүүжүүлэх дүн: 901,836,561 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 856,744,732 төгрөг

Барилгын ажлын явцын зураг: Дууссан.



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Өвс тэжээлийн агуулахын барилга:

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Логмон ХХК

Санхүүжүүлэх дүн: 370,125,833 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 351,619,541 төгрөг

Барилгын ажлын явцын зураг: Дууссан.



(ii) Байгаль орчин менежмент:

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Мөнх-Өргөө ХХК-тай “Ханбогд сумын хог хаягдлын ландфиллын байгууламж барих төсөл санхүүжүүлэх гэрээ” байгуулсан. Гэрээний нийт дүн нь 591,422,413 төгрөг бөгөөд төслийн ажлын зураг төсөлд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор тайлант онд санхүүжилт олгоогүй байна.

(iii) Нийгэмд чиглэсэн сургалт, үйлчилгээ:

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2019 оны 10 дугаар сарын 25-ний өдөр Элбэг туулай ХХК-тай “Манлай сумын цэцэрлэгийн тоног төхөөрөмж” төслийн гэрээ байгуулсан байгуулсан. Гэрээний нийт дүн нь 165,056,900 төгрөг. Тайлант онд Хөгжлийг дэмжих сангаас 156,804,055 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Говийн Оюу ХДС, НҮБ-ын хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл Мэндийн байгууллага, Австралийн Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хамтран Өмнөговь аймгийн “Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-аас тайлант онд 1,180,310.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

(iv) Орон нутгийн бизнес хөгжил:

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Олон улсын санхүүгийн корпорацын хамтарсан санхүүжилтээр Даланзадгад суманд “Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийн хөгжүүлэх” хөтөлбөрийг 3 жилийн хүрээнд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд тайлант онд 1,055,250.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

(v) Усны менежмент:

Чандмань эрдэнэ хөтөлбөрийн хүрээнд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь Хишиг-Юниверс ХХК, Халбас хайрханы хишиг ХХК, Баянговь ус ХХК зэрэг компанитай “Худаг гаргах, худаг засварлах ажлыг санхүүжүүлэх” гэрээг байгуулж нийт 260,901.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

(vi) Хандив тусламж

Говийн Оюу ХДС-ийн “Төсөл хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”, “Хандив тусламжийн удирдамж” болон хандив тусламжийн хорооны зөвшөөрлийн дагуу тайлант хугацаанд нийт 349,088.7 мянган төгрөгийг Өмнөговь аймгийн сумуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж өгсөн байна.

(vii) Тэтгэлэгт хөтөлбөр:

Сангаас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймагт дутагдалтай

байгаа мэргэжлээр улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцаж байгаа нийт 55 оюутанд 126,149.8 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

3.9 Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Үндсэн ба нэмэгдэл цалин	171,048.0	201,829.6
Нийгмийн даатгалын шимтгэл	20,525.7	25,131.9
Удирдах зөвлөхийн хурлын зардал	17,422.5	28,435.0
Зар сурталчилгаа, хэвлэлийн зардал	151,070.3	107,160.8
Оффис түрээсийн зардал	16,988.4	17,038.2
Сургалтын зардал	-	5,007.9
Бичиг хэргийн зардал	8,987.1	8,683.8
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,130.6	511.8
Элэгдлийн зардал	13,566.2	14,538.5
Шуудан холбооны зардал	3,834.2	4,260.8
Хангамжийн материалын зардал	3,511.8	4,644.0
Засварын үйлчилгээний зардал	714.6	1,952.7
Зөвлөх үйлчилгээний зардал	106,265.7	27,600.0
Хяналтын зардал	-	3,867.9
Албан томилолтын зардал	4,267.5	1,600.0
Шатахууны зардал	7,097.6	10,883.9
Сэлбэг, багаж хэрэгсэл, засварын зардал	-	6,488.7
Бусад зардал	15,052.0	21,490.0
Дүн	<u>541,482.2</u>	<u>491,125.5</u>

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын үйл ажиллагааны зардлын жилийн нийт төсөв нь тухайн жилийн нийт санхүүжилтийн 5 хувь хүртэл байхаар 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн удирдах зөвлөлийн хурлын №01 тоот тогтоолоор шинэчлэн баталсан.

Үйл ажиллагааны зардалд “Хамтын ажиллагааны гэрээ”-г зөв зохистой, ил тод хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлага, зохион байгуулалт болон сангийн ажилтантай холбоотой зардлууд багтдаг.

3.10 Үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардал

	2018.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Валютын ханшийн зөрүүний олз	150,000.0	0.0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	1,147.1	0.0
Дүн	<u>148,852.9</u>	<u>0.0</u>

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №11 тоот тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлах боломжгүй болсон 3 ширхэг зөөврийн компьютер данснаас хасах тухай шийдвэр гаргасан.

3.11 Холбоотой тал

Холбоотой талын нэр	Харьяалал	Хамаарал	Ажил гүйлгээ
Оюу Толгой ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
Өмнөговт аймаг, Хан богд сум бүсэд түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажилгааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг
Тим Экерсли	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт
Х. Сугир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Лаура Томас	Австрали улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Д.Амар баясгалан	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Ш.Байгалмаа	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирал	Цалин

3.12 Болзошгүй өр төлбөр

2019 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

3.13 Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Тайлант хугацаа дуусгавар болсноос хойш 2020 оны 7 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн тайланд нөлөөлөх аливаа үйл явдал гараагүй байна.

3.14 Тайлангийн орчуулга

Аудитын тайланг, тодруулгын хамт монгол, англи хэлээр тус бүр 2 хувь бэлтгэсэн бөгөөд эдгээрт утгын зөрүү гарвал монгол эх хувийг баримтлах болно.



2020 ОНЫ 07 ДУГААР
САРЫН 21-НИЙ ӨДӨР

